



## **Эрдэнэ Ресурс нь Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг танилцууллаа**

**Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2018 оны 12 сарын 18**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (Цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Төслийн анхан шатны бөгөөд хөндлөнгийн эдийн засгийн тооцооллыг (“PEA”) танилцуулж байгаадаа таатай байна. Анхан шатны эдийн засгийн тооцооллыг RPMGlobal Ltd (Хонг Конг) компани NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын (“National Instrument 43-101” эсвэл “NI 43-101”) дагуу боловсруулсан. Компани нь Хойд Америкийн зүүн бүсийн стандарт цагаар (“EST”) 10:00 цагт эдгээр үр дүнг танилцуулах цахим хурал товлогдсон. Компанийн вебсайт дээр цахим хурлын бичлэг тавигдана. Энэхүү хуралд оролцох хүсэлтэй байвал доорх дугаарын дагуу залгана уу. Дуудлагын дараа асуулт хариултууд компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-д тавигдана.

Дуудлагын хугацаа: 2018 оны 12 сарын 18-ны Мягмар гаргийн өглөөний 10:00 цагт (Зүүн бүсийн стандарт цаг, EST)

Канад/АНУ-аас залгах дугаар: 1-877-703-1560

Олон улсын залгах дугаар: 1-647-689-5569

### **Анхан шатны эдийн засгийн тооцооллын онцлох мэдээллүүд**

- Татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хоргодуулалт бүхий) (“NPV5%”) болон дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр \$99 сая ам.доллар болон 56% (алтны үнийг \$1,200/унц-аар төсөөлөн тооцоолсон)
- Татварын өмнөх өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хоргодуулалт бүхий) (“NPV5%”) болон дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр \$135 сая ам.доллар болон 70% (алтны үнийг \$1,200/унц-аар төсөөлөн тооцоолсон)
- Анхны хөрөнгө оруулалт: 32 сая ам.дол
- Нэг унц алт үйлдвэрлэх зардал (“AISC”) нь \$714 ам.доллар
- Ашиглалтын хүдрийн дундаж агуулга 3.42 г/т
- Жилд олборлох алтны дундаж хэмжээ: 51,200 унц, нийт олборлох алтны хэмжээ 412,000 унц
- Уурхайн ашиглалтын хугацаа: 8 жил (уурхай байгуулах 1 жил болон уурхайн хаалтын хугацааны 2 жил ороогүй)
- Эргэн төлөгдөх хугацаа: 2 жил

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ “Хөндий Алтны Төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллоор төслийн анхан шатны хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал бага, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа богино, илээр олборлох боломжтойг харууллаа”. “Энэхүү төсөл нь Монгол улсын алтны нөөцийг нэмэгдүүлээд зогсохгүй алслагдмал бүсэд үйлдвэрлэл, ажлын байр бий болгох ач холбогдолтой. Бид олон жилийн турш Монгол улсад хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай бөгөөд энэхүү төслийг хөгжүүлэн, оролцогч талуудад үнэ цэнийг бий болгохоор зорин ажиллаж байна.”

“Бидний дараагийн алхмуудад: ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахтай зэрэгцэн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, түүнчлэн 2019 оны эхээр уурхай байгуулалт, үйл ажиллагааны зөвшөөрөл авах ажлууд төлөвлөгдөж байна. Мөн бид Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдлөгийн судалгааг үргэлжлүүлэн хийх бөгөөд эргэн тойрны талбайд хайгуулын ажлуудыг гүйцэтгэж, тухайн бүс нутагт шинээр олгох тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар авах боломжуудыг судална.” хэмээн Петер Акерли дурдсан юм.

#### **Анхан шатны эдийн засгийн тооцооллын тухай**

Анхан шатны эдийн засгийн тооцооллыг компанийн Баян Хөндий алтны төслийн (“Баян Хөндий”) 2018 оны 9 сард танилцуулсан анхан шатны нөөцийн тайлан (2018 оны 9 сарын 18-ны хэвлэлийн мэдээтэй танилцана уу) болон түүнээс 16 км зайд орших Алтан Нар алтны төслийн (“Алтан Нар”) 2018 оны 5 сард шинэчлэн боловсруулсан нөөцийн тайланд (2018 оны 5 сарын 10-ны хэвлэлийн мэдээтэй танилцана уу) тулгуурлан боловсруулав. Баян Хөндий орд нь 3.65 г/т дундаж агуулга бүхий 2.7 сая тонн хүдрийн нөөц, үүний 98%-ийг баттай ба бодит ангиллын нөөцийн хүдэр бүрдүүлж байна. Алтан Нар орд нь 3.11 г/т дундаж агуулга бүхий 1.9 сая тонн хүдрийн нөөцтэй, үүний 70%-ийг баттай ба бодит ангиллын хүдрийн нөөц бүрдүүлж байгаа боловч анхан шатны эдийн засгийн тооцоололд боломжит нөөцийн тодорхой хэсгийг багтаав. Дээрх ордуудыг хамтад нь “Хөндий Алтны Төсөл” хэмээн нэрлэж хөгжүүлнэ.

Анхан шатны эдийн засгийн тооцооллоор өндөр агуулга бүхий ил аргаар олборлох боломжтой Баян Хөндий төслийн Страйкер бүсээс эхлэн олборлож, цаашид Баян Хөндийн зэргэлдээ орших бүсүүд болон Алтан Нар төслийн талбайд олборлолт хийхээр төлөвлөж байна. Хөгжүүлэлтийн төлөвлөгөөнд уламжлалт нүүрсэнд уусгах технологи болон гравитациар баяжуулах аргаар өдөрт дунджаар 1,800 тонн хүдэр боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөгдөв.

Эдгээр тооцооллууд нь алтны үнийг ирээдүйд \$1,200/унц байна гэдэг төсөөлөлд тулгуурласан. Мөн тооцооллууд дахь валют нь тусгайлан заагаагүй тохиолдолд Америк доллараар тодорхойлогдоно. NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулсан Анхан шатны эдийн засгийн тооцооллын тайланг 45 хоногийн дотор SEDAR-г бүртгүүлнэ.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоолол нь боломжит нөөц дээр тулгуурласан болно. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл өндөртэй. Ашигт малтмалын геологийн нөөцийг ашиглалтын нөөц гэж үзэхгүй бөгөөд эдийн засгийн ач холбогдолтой гэдгийг нь харуулах баталгаа байхгүй боловч эдийн засгийн үр ашигтайгаар олборлох боломжийн хэтийн төлөвтэй гэж ойлгоно.

Төслийн тухай голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 1-ээс харна уу. Хөндий Алтны Төслийн уурхайн байршлын зургийг энэхүү хэвлэлийн мэдээнд хавсаргав.

#### Хүснэгт 1. Анхан шатны эдийн засгийн тооцооллын үзүүлэлтүүд

Төсөөлөл		
Алтны үнэ	US\$/унц	1,200
Олборлолт		
Уурхайн ашиглалтын хугацаан дахь хүдрийн дундаж агуулга <sup>1</sup>	г/т алт	3.42
Төслийн хугацаа <sup>2</sup>	жил	11
Уурхайн ашиглалтын хугацаа	жил	8
Өдөрт боловсруулах хүдрийн хэмжээ <sup>3</sup>	тонн	1,800
Жилд олборлох алтны хэмжээ	унц	51,200
Жилд олборлох алтны дээд хэмжээ	унц	68,100
Ашиглалтын хугацаанд олборлох нийт алт	унц	412,000
Ашиглалтын хугацааны дундаж металл авалт	%	82%
Хөрс хуулалтын харьцаа ("Strip Ratio")	тонн:тонн	10.5:1
Нэг унц алт үйлдвэрлэх зардал ("AISC") <sup>4</sup>	US\$/унц	714
Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд, татварын өмнөх бодит үнэ цэн		
5% хорогдуулалттай татварын өмнөх өнөөгийн үнэ цэн ("NPV5%")	сая ам.дол	135
7.5% хорогдуулалттай татварын өмнөх өнөөгийн үнэ цэн ("NPV7.5%")	сая ам.дол	119
10% хорогдуулалттай татварын өмнөх өнөөгийн үнэ цэн ("NPV10%")	сая ам.дол	105
Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд, татварын дараах бодит үнэ цэн		
5% хорогдуулалттай татварын дараах бодит үнэ цэн ("NPV5%")	сая ам.дол	99
7.5% хорогдуулалттай татварын дараах бодит үнэ цэн ("NPV7.5%")	сая ам.дол	86
10% хорогдуулалттай татварын дараах бодит үнэ цэн ("NPV10%")	сая ам.дол	76
Дотоод өгөөжийн түвшин болон буцаан төлөх хугацаа		
Татварын өмнөх дотоод өгөөжийн түвшин ("IRR")	%	70
Татварын дараах дотоод өгөөжийн түвшин ("IRR")	%	55
Эргэн төлөх хугацаа <sup>5</sup>	жил	1.9
Капиталын нөхцөлүүд		
Тооцоолоогүй зардал багтсан олборлолтын өмнөх зардлууд	сая ам.дол	32
Ашиглалтын хугацааны хөрөнгө оруулалтуудын зардал	сая ам.дол	8

1. Хүдрийн дундаж агуулга

2. Төслийн хугацаанд уурхай байгуулах 1 жил, олборлолт хийх 8 жил болон уурхайн хаалтын 2 жил багтсан

3. Үйлдвэр нь жилд 8,000 цаг ажиллаж, жилд 600,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай байна

4. Үйл ажиллагааны зардал нь цутгасан алтаар тайлагнагдан, US \$62/унцаар тооцоологдсон Монгол улсын Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр ("AMHAT") болон цэвэршүүлэх зардлууд багтсан

5. Эргэн төлөх хугацааг татварын дараах хорогдуулалт хийгээгүй мөнгөн гүйлгээнд тулгуурлан тооцоолсон

## Мэдрэмтгий байдлын судалгаа

Доорх хүснэгтэд алтны үнээс шалтгаалан өнөөгийн үнэ цэн (NPV) болон дотоод өгөөжийн түвшин (IRR) хэрхэн өөрчлөгдөхийг харуулав. Үзүүлэлтүүд алтны үнийн өсөлт бууралтад төслийн уян хатан байдал ямар байгааг харуулж байна.

### Хүснэгт 2. Мэдрэмтгий чанарын судалгаа

Мэдрэмтгий чанарын судалгаа	Нэгж	\$1,150	\$1,200	\$1,250	\$1,300
NPV (5% хорогдуулалттай)	Сая ам.дол	87	99	111	123
NPV (7.5% хорогдуулалттай)	Сая ам.дол	76	87	97	108
NPV (10% хорогдуулалттай)	Сая ам.дол	66	76	86	96
IRR	%	51%	56%	62%	67%

## Олборлолт

Уурхай нь жилд 600,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээх байдлаар төлөвлөгдөж байна. Олборлох боломжтой хэмжээг 4.5 сая тонн, үүнд 3.42 г/т дундаж агуулга бүхий хүдэр багтсан бөгөөд хөрс хуулалтын харьцаа 10.5:1 байна. (тонн хаягдал: тонн үйлдвэр тэжээх хүдэр)

Хүдэржилтийн 70% нь газрын гадаргад ойр буюу хүдрийн дийлэнхи хэсэг нь 115 метрийн гүнд байна. Ордын бүтэц, агуулга болон гүнээс шалтгаалан ил уурхайн аргаар ашиглах боломжтой. Одоогийн төлөвлөж буй ил уурхайгаас доош далд уурхайн ашиглалтын боломж нь энэхүү анхан шатны эдийн засгийн тооцоололд багтаагүй бөгөөд ирээдүйд судалгаа хийгдэх боломжтой.

Ашиглалтын үед урвуу хутгуурт гидравлик экскаватор ашиглана. Тэсэлсэн хөрс, материалыг автосамосвалд ачин, хаягдал материалыг уурхайтай залгаа орших хаягдлын овоолгод хуримтлуулан, хүдрийг боловсруулах үйлдвэртэй зэрэгцэх тээрэм рүү шилжүүлнэ. Алтан Нар орд нь хүдэр боловсруулах үйлдвэрээс 19 км зайд орших тул газраар болон галт тэргээр Баян Хөндий рүү тээвэрлэгдэнэ.

## Боловсруулалт

Хүдрийг боловсруулахдаа уламжлалт буюу гравитациар баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баян Хөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,800 тонн хүдэр, жилд 600,000 тонн хүдэр боловсруулна. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 4.6 сая тонн хүдрийг боловсруулах бөгөөд 3.42 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулна. Төслийн хугацаанд дундаж металл авалт 82%, байх ба нийт 412,000 унц алт олборлоно.

Баян Хөндий ордын хүдрийг боловсруулалт хийснээр дундаж металл авалт 92%-тай байна Алтан Нард хүнцлийн колчеданы хүдэр багтаж байгаа тул анхан шатны эдийн

засгийн тооцоололд ордын хүдрийг боловсруулалт хийснээр металл авалт дунджаар 62% байх боломжтойг багтаасан.

### Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал нь дээр дурдсан олборлолтын болон боловсруулалтын хувилбар дээр үндэслэж тооцоологдсон, ингэхдээ гэрээт олборлогчтой ажиллахаар төлөвлөв. Бусад бүх үйл ажиллагааг компани өөрөө хариуцан ажиллана. Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр болон түүнтэй холбоотой зардлаас бусад зардал дээр тооцоологдоогүй 10%-ийн зардал нэмэгдсэн. Нэг унц алт үйлдвэрлэх зардал \$714 ам.доллар байна.

#### Хүснэгт 3. Үйл ажиллагааны зардал

Зардлууд	Уурхайн ашиглалтын хугацаанд		
	\$ сая ам.дол	\$ ам.дол/унц	\$ ам.дол/тонн
Уурхайн үйл ажиллагааны зардал	134	326	29
Боловсруулалтын зардал	76	183	16
Ерөнхий ба захиргааны зардал	30	73	7
Бүтээгдэхүүний зардал	2	6	1
Нөөц ашигласны төлбөр болон бусад зардал	26	62	6
Тооцоологдоогүй зардлууд	24	58	5
Нийт үйл ажиллагааны зардал	292	708	64
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт	3	6	1
Нэгжийн зардал	295	714	65

### Хөрөнгийн зардал

Уурхай байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг (0 жилд) 32 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Хэрэв түрээсийн тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлага гарвал хөрөнгийн зардал дээр 38 сая ам.доллар нэмэгдэнэ. Боловсруулах үйлдвэр болон холбогдох байгууламжууд Баян Хөндийд байрлана. 3 дахь жилээс эхлэн Алтан Нартай холбох дэд бүтэц нь 1 сая ам.долларын өртгөөр бүтэх бөгөөд дээрх бүх зардлууд дээр нэмж 20% тооцоолоогүй зардал багтсан.

Уурхайн төлөвлөлтөд 3 сая ам.доллар, уурхайн хаалтад 4 сая ам.долларын тогтвортой хөрөнгийг тусгасан. Төслийн ашиглалтын хугацааны нийт хөрөнгийн зардлыг 40 сая ам.доллараар тооцоолсон.

#### Хүснэгт 4. Хөрөнгийн зардал

	Баян Хөндий (\$ сая ам.дол)	Алтан Нар (\$ сая ам.дол)	Нийт (\$ сая ам.дол)
Баяжуулах үйлдвэр	16	-	16

Барилга байгууламж	3	-	3
Байр, орон сууц	2	-	2
Нислэгийн зурвас	1	-	1
Зам	1	1	2
Мэргэжлийн ажил үйлчилгээ	4	-	4
Мэргэжлийн үйлчилгээнд тооцоогүй зардал	5	-	5
<b>Үйлдвэр болон дэд бүтэц</b>	<b>32</b>	<b>1</b>	<b>33</b>
Уурхайн хаалт	3	1	4
Тогтвортой хөрөнгө оруулалт	2	1	3
<b>Нийт</b>	<b>37</b>	<b>3</b>	<b>40</b>

### Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжууд

Хөндий Алтны Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжууд:

- Өндөр агуулга: Энэхүү орд нь өндөр агуулга бүхий орд тул цаашид олборлолтын шатанд тооцоолсноос өндөр агуулга бүхий бүсийг нээн илрүүлэх магадлалтай гэж үзэж байна. Анхан шатны эдийн засгийн тооцоололд блок загварт хамгийн өндөртөө 55 г/т алтны агуулга багтсан. Харин өрөмдлөгийн судалгааны үед 50 г/т-оос 2200 г/т хүртэл 40 гаруй интервалуудыг огтолсон.
- Баян Хөндийн нэмэлт нөөц: Анхан шатны эдийн засгийн тооцоололд төлөвлөсөн ил уурхайн бүсэд ороогүй хэсэгт дунджаар 4 г/т алтны агуулга бүхий 60,000 унц бодит, 70,000 унц боломжит нөөц байна. Энэхүү нөөц нь Баруун Страйкер бүсэд, уурхайн хананаас 100 метрийн орчимд 100 метрийн гүнд оршиж байна. Ирээдүйд энэхүү нөөцийг далд аргаар олборлох талаар судалгаа хийгдэнэ.
- Алтан Нарын нэмэлт нөөц: Алтан Нард тооцоологдсон дийлэнх нөөц нь энэхүү анхан шатны эдийн засгийн тооцоололд бүрэн тусгагдаагүй. Ирээдүйн хөгжүүлэлтэд багтаахад нэмэлт өрөмдлөг болон металлургийн судалгаа хийх шаардлагатай.
- Хайгуулын боломж: Баян Хөндий болон Алтан Нар ордууд нь хайгуул бага хийгдсэн, хэтийн төлөв өндөр бүсэд оршдог. Компани нь энэхүү бүс дэх хамгийн том хайгуулын мэдээллийн санг эзэмшдэг бөгөөд цаашид хайгуулын судалгаа хийх болон тусгай зөвшөөрлийн талбай худалдан авах замаар нөөц нэмэгдүүлэх боломжтой.
- Металл авалтыг нэмэгдүүлэх: Баян Хөндийн хүдэржилтээс харахад металл авалт дунджаар 92% байна. Мөн өндөр агуулга бүхий хүдрийг уусгах аргаар шалгаж үзсэн бөгөөд металл авалт 99% хүртэл өссөн. Цаашид нэмэлт металлургийн судалгаа хийснээр металл авалтыг нэмэгдүүлэх боломжтой. Алтан Нар ордын хувьд хүнцлийн колчеданы хүдэр багтаж байгаа тул дундаж металл авалт 62% байна. Алтан Нарын Нээлтийн бүсийн дээжийг уусгах аргаар дахин шалгахад металл авалт 88% хүртэл нэмэгдэх боломжийг харуулсан, үүнтэй холбоотойгоор ирээдүйд нэмэлт металлургийн судалгааг хийнэ.

- Уурхайн төлөвлөлт: Анхан шатны эдийн засгийн тооцооллоор Хөндий Алтны Төслийн уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх талаар эхний алхмуудыг танилцуулсан. Цаашид уурхайн төлөвлөлтийг сайжруулах, хаягдал зөөвөрлөлт, бохирдлыг бууруулах, ашиглалтын техникийн аргачлалыг сайжруулах зэргээр зардлыг бууруулах боломжуудыг судална.
- Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт: Голлох бус тоног төхөөрөмжийг 2-р зэргийн ханган нийлүүлэгчээс авч хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг бууруулах аргыг судлах боломжтой.
- Монгол улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам нь хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэн бөгөөд 2019 онд хэтийн төлөв бүхий тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох боломжтой. Компани нь хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон бөгөөд энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна.

### **Холбогдох эрдсийн нөөцийн тооцоолол**

Анхан шатны эдийн засгийн тооцооллыг хоорондоо 16 км-ийн зайд орших Баян Хөндий алтны төсөл болон Алтан Нар алтны төслийн нөөцийн тайланд тулгуурлан NI 43-101 стандартын дагуу боловсруулсан. Эдгээр хоёр төслүүдийг нэгтгэн Хөндий Алтны Төсөл хэмээн нэрлэдэг. Энэхүү төсөл нь өндөр агуулга бүхий газрын дөт гүнд оршдоогоороо онцлог бөгөөд 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 751,000 унц алтны бодит нөөц, 1.8 г/т алтны дундаж агуулга бүхий 291,000 унц алтны боломжит нөөц тогтоогдсон. 1.4 г/т захын агуулгаар тооцоход 3.7 г/т алтны дундаж агуулгатай 642,000 унц алтны бодит нөөц, үүнд 2.3 г/т алтны дундаж агуулгатай 250,000 унц боломжит нөөц багтаж байна.

Баян Хөндий орд нь 3.65 г/т хүдрийн дундаж агуулгатай 2.7 сая тонн нөөц, үүнээс 98% нь баттай болон бодит нөөцийн ангилалд багтаж байна. Алтан Нар орд нь 3.11 г/т хүдрийн дундаж агуулга бүхий 1.9 сая тонн нөөц, үүнээс 70% нь баттай болон бодит нөөцийн ангилалд багтаж байна.

### **Хөндий Алтны Төслийн ирээдүйн төлөвлөгөө**

Анхан шатны эдийн засгийн тооцооллоор Хөндий Алтны Төсөл нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэсэн үр дүнг харуулсан бөгөөд RPM нь техникийн судалгааг үргэлжлүүлэн урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулахыг зөвлөсөн. Компани нь 2019 онд ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргахад зориулан холбогдох олборлолт, геотехник, металлург, хаягдлын удирдлага, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн болон гидрогеологийн судалгааг хянах, дэмжлэг үзүүлэх Ашиглалтын Судалгааны Багийг бүрдүүлсэн.

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндийн ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай ажлуудыг энэ онд эхлүүлж, холбогдох мэдээлэл, тайланг бэлтгэсэн байгаа. Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөс томилогдсон шинжээчид энэхүү хүсэлтийг хянан,

дүгнэлтээ гаргана. 2019 оны 1-р улиралд болох Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаас өмнө шинжээчид ордын байршил дээр хяналт, судалгаа хийхээр төлөвлөж байна. Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2019 оны эхээр гаргахаар төлөвлөж байна.

2020 оны эхэн гэхэд тусгай зөвшөөрөл, техник эдийн засгийн үзүүлэлт болон төслийн санхүүжилтийг эцэслэн, 2020 онд уурхайн бүтээн байгуулалтыг эхлэхээр төлөвлөж байна. Уурхайн байгуулалтыг эцэслэн, олборлолтыг эхлүүлэхэд нэг жил шаардана гэж төсөөлж байна.

### **Хөндий алтны төслийн тухай**

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпитеpmаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг олгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Компани нь Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн хайгуул болон нөөцийн хөгжүүлэлтэд 17 сая ам.долларын хөрөнгө зарцуулаад байна.

### **Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол**

Хөндий Алтны Төслийн анхан шатны эдийн засгийн тооцоололтой холбоотой гаргаж буй энэхүү хэвлэлийн мэдээг RPM. Advisory Services Pty Limited-ийн ажилтан, Австралийн Уул уурхай, металлургийн институтийн судлаач ноён Игор Бояаникийн нэгтгэн, боловсруулсан мэдээлэлд тулгуурлан бэлтгэв. Ноён Игор Бояаник нь NI 43-101-д заасан Мэргэшсэн этгээдийн шаардлагыг хангасан төдийгүй дээрх мэдээлэлд дурдсан ордын шинж чанар, хүдэржилтийн талаар арвин туршлагатай мэргэжилтэн юм.

Ноён Игор Бояаник нь энэхүү судалгаатай холбоотойгоор ямарваа сонирхлын зөрчил байхгүй болно.

Майкл МакДоналд (Michael MacDonald) нь Компанийн Хайгуул хариуцсан дэд ерөнхийлөгч (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба тэрээр энэхүү хэвлэлийн мэдээнд Анхан Шатны Эдийн Засгийн Тооцооллоос бусад техникийн мэдээллийг Эрдэнэ Ресурсийн өмнөөс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс



лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн.

### **Компанийн тухай**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн тухай тодорхой баттай мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайт дээр байрших тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан дэлгэрэнгүй мэдээлэл авах нь тохиромжтой.

### **Урьдчилсан таамаглал**


Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай, ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Хувьцааны ханшид нөлөөлж болохуйц материаллаг хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй. Мөн энэхүү хэвлэлийн мэдээллийн Монгол болон Англи хувилбарт орчуулгын зөрүү гарсан тохиолдолд Англи хувилбар нь гол дагах эх нь байна.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

### **Холбоо барих:**

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал  
Кэн В. МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал  
Утас: (902) 423-6419  
Email: [info@erdene.com](mailto:info@erdene.com)  
Вебсайт: [www.erdene.com](http://www.erdene.com)  
Твиттер: <https://twitter.com/ErdeneRes>

Зураг 1 – Хөндий Алтны Төслийн уурхайн байршлын зураглал



RPMGLOBAL

0 4000m 8000m

PROJECTS/THIS DRAWING - LEGEND/CONDITIONS ONLY. NOT FOR REPRODUCTION OR SITE

CLIENT

ERDENE  
HUBGOLDOЛГОЛЖОО

PROJECT

NAME: Bayan Khundii Resource Estimate Technical Report

DRAWING: BAYAN KHUNDII and ALTAN NAR PROPOSED PITS, DUMPS, ROM and MIA LOCATIONS

FIG. REF.:	PROJECT No.	Date
4-X	ADV-MN-00161	November 2018